



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26 04-37, Факс: (976) 6226 3230,  
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23 № 3/299  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын, Санхүү хангамжийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Цагдаагийн ерөнхий газрын, Санхүү хангамжийн газрын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.


Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

### **Зөрчилгүй санал дүгнэлт**

Цагдаагийн ерөнхий газрын, Санхүү хангамжийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



**УАГ**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## ЦЕГ-ЫН САНХҮҮ ХАНГАМЖИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг  
хүсвэл дараах хаягаар  
харилцана уу:**

УАГ-ын Санхүүгийн аудитын  
газрын дарга Ц.Наранчимэг  
Утас: 261663  
Цахим хаяг:  
[naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер:  
Г.Гүнжидмаа  
Утас: 261740  
Цахим хаяг:  
[gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)

Шинжээч : Д.Цэгмиддорж  
Утас: 261740  
[tsegmiddorjd@audit.gov.mn](mailto:tsegmiddorjd@audit.gov.mn)

Монгол Улсын Үндэсний  
аудитын газар

Засгийн газрын IY байр  
Улаанбаатар-46  
Бага тойруу 6

Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

АГУУЛГА

ХУУДАС

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хавсралт 5: Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

## АГУУЛГА

---

1.	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл.....	3
2.	Байгууллагын хууль, эрх зүйн орчин.....	3
3.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа.....	4
4.	Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн.....	4
5.	Дотоод хяналт.....	4
6.	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар.....	5
7.	Шилэн дансны мэдээлэл.....	5
8.	Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар.....	5
9.	Гол, онцлог гүйлгээний талаар.....	5
10.	Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар.....	6
11.	Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар.....	6
12.	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	6
13.	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	7
14.	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	7
15.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	7
16.	Зөвлөмж .....	7
17.	Аудитын гэрчилгээний талаар санал дүгнэлт дүгнэлт.....	7

## **Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл**

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2, 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд ЦЕГ-ын Санхүү хангамжийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд САГ-2017/45/СТА-ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

ЦЕГ-ын Санхүү хангамжийн газрын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ЦЕГ-ын Санхүү хангамжийн газрын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын Ахлах аудитор Ж.Батсайхан, Аудитор Ш.Отгонбаяр, Шинжээч Д.Цэгмиддорж нар хэрэгжүүлж ажиллав.

ЦЕГ-ын Санхүү хангамжийн газрын 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

## **Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин**

Цагдаагийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг ашиглаж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

## **Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа**

Цагдаагийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-т “Цагдаагийн төв байгууллагын дэмжлэг үзүүлэх нэгжийн харъяанд судалгаа, сургалт дадлагын болон албаны зэвсэг, тусгай хэрэгсэл, тусгай зориулалтын техник хэрэгслийн чанар стандартыг судлан тогтоох лаборатори, энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах инженер техник, засвар үйлчилгээ, үйлдвэрлэл, санхүү, хангалт хариуцсан нэгж” байна гэсэн заалтыг үндэслэн үйл ажиллагаагаа явуулж байна.

## **Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар ЦЕГ-ын Санхүү хангамжийн газрын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 8 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 1 хувиар тооцож 299.2 сая төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В1/

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Аcolous” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

## **Тав. Дотоод хяналтын талаар**

Санхүүгийн хэлтсээс 2016 онд төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд хэсэгчилсэн дотоод хяналт хийж, зөвөлгөө өгөх ажлын хуваарийн дагуу Говьсүмбэр аймаг дахь Цагдаагийн хэлтэс, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын Хамгаалалтын 3 дугаар газар, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын Хамгаалалтын 1 дугаар газар, Орхон, Ховд, Завхан аймаг дахь Цагдаагийн газар, Төмөр зам дахь Цагдаагийн хэлтэс, Санхүү, хангамжийн газар, Автобааз, Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэс, Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газар, Эрүүгийн цагдаагийн газар, Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн тасаг, Мөрдөн байцаах газар, Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны төвийн санхүүгийн үйл ажиллагаанд хэсэгчилсэн дотоод хяналт хийж өөрийн орлогын бүрдүүлэлт, төсвийн хөрөнгийн зарцуулалт, цалин хөлс олголт, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн ногдуулалт, эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, тооллого, тооцоо бодолт, өр авлагын барагдуулалт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалтын байдалд хэсэгчилсэн дотоод хяналт хийж

илэрсэн зөрчлийг арилгуулан, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч зөвлөмж бичиж биелэлтийг тооцон ажилласан байна.

### **Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар**

“Цагаан шонхор” УУГ-тай өвлийн хүрэм өмд 1100 хосыг 95.3 сая төгрөгөөр, зуны хантааз 7700 ширхэгийг 61.6 сая төгрөгөөр, цагдаагийн алба хаагчдын албаны китель, өмд 3200 хосыг 208.0 сая төгрөгөөр, цагдаагийн алба хаагчдын ёслол, амралтын богино ханцуйтай цагаан өнгийн цамц 7000 ширхэгийг 217.0 сая төгрөгөөр, “Сокол” ХХК-тай цагдаагийн алба хаагчдын борооны цувны хослол 10000 ширхэгийг 698.0 сая төгрөгөөр, “Эс Сайн” ХХК-тай цагдаагийн алба хаагчдын албаны богино ханцуйтай цамц 7000 ширхэгийг 217.0 сая төгрөгөөр, цагдаагийн алба хаагчдын албаны урт ханцуйтай цамц 7000 ширхэгийг 229.6 сая төгрөгөөр хийлгүүлэхээр гэрээ байгуулж Хангалт үйлчлэгээний төв дээр цагдаагийн албан хаагчдын дүрэмт хувцсыг орлогод авсан байна.

Цагдаагийн ерөнхий газрын 2016 онд 2,900.0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө баталснаас нийт 2.909,0 сая төгрөгийн орлогыг ЦЕГ-ын Санхүү хангамжийн газрын 9000120408 тоот дансанд төвлөрүүлсэн байна. Улсын тэмдэгтийн хураамжид 368.1 сая төгрөг, нэр данс зөрүү, данс андуурсан гүйлгээнд 2.9 сая төгрөгийн гүйлгээг шилжүүлж, төсөвт байгууллагын төвлөрүүлэх шилжүүлэгт 2.537,9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Орлогын төлөвлөгөө тасарсан нь 2016 оны 05 болон 06 дугаар саруудад жолооны үнэмлэхний бэлдэц тасарч, хэвлэлт зогссонтой холбоотой байна.

### **Долоо. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар**

Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ЦЕГ-ын Санхүү хангамжийн газрын 2016 онд Шилэн дансны нэгдсэн портал системийн цахим хуудас <http://www.shilendans.gov.mn>, Цагдаагийн ерөнхий газрын [www.police.gov.mn](http://www.police.gov.mn) байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт мэдээллүүдийг хуулийн хугацаанд нь байршуулж ажиллаж байна. Тайлант онд 141 мэдээллийг байршуулсан байна.

### **Найм. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 8 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

### **Ес. Гол, онцлог гүйлгээний талаар**

Тус байгууллагын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн элэгдэл, бусад орлого, цалин, ЭМД, НДШ, ХХОАТ, халаалт, цахилгаан, шатахууны зардал зэрэг дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Наадмын хамгаалалтын 268.6 сая төгрөгийн зардлын төсвөөс, гүйцэтгэлээр 268.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийг нийт 241 албан хаагчдад 5,931.8 сая төгрөгийг олгосон байна. УИХ болон аймаг,

нийслэлийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын ээлжит сонгуулийн хамгаалалтын зардалд 361.6 сая төгрөгийн төсөв батлагдснаас, гүйцэтгэлээр 360.8 сая төгрөгийг зарцуулсан буюу 0.2 хувиар хэмнэсэн, мөн сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын ээлжит сонгуулийн хамгаалалтын зардалд 293.1 сая төгрөгийн төсөв батлагдснаас, гүйцэтгэлээр 285.4 сая төгрөгийг зарцуулсан буюу 2.6 хувиар хэмнэсэн байна. Дээрх сонгуулиудын зардлаас хэмнэсэн нийт 8.5 сая төгрөгийг улсын төсвийн орлогын дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

### **Арав. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар**

Аудитаар Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- Жижиг мөнгөн сангийн нийт 87.6 сая төгрөгийн 126 ажил гүйлгээг түүвэрлэн шалгахад, ЦЕГ-ын харьяа бусад газруудтай холбоотой 2.3 сая төгрөгийн зардлыг тус байгууллагын баталсан төсвөөс санхүүжүүлсэн байна.
- Нэмэлт төсвийн данснаас санхүүжүүлсэн 11 томилолтын батлагдсан зардлын төсөв зөрүүтэй хийгдсэн, нийт явах километр, зарцуулах шатахууныг зөрүүтэй бодож тооцоолсон байна.
- Улсын филармонтой байгуулсан ажил гүйцэтгэх 2 гэрээний нийт 8.8 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас санхүүжүүлээгүй ба дэрх зардлыг ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшууллын зардлаас санхүүжүүлсэн байна.

**Шийдвэрлэсэн нь:** “Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 2-р хавсралтанд заасан зардлын эдийн засгийн ангиллыг дагаж мөрдөх, дотоод хяналтыг сайжруулах

- Тус байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусч элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй 15.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 2.7 сая төгрөгийн бараа материал бүртгэлтэй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Ашиглалтын хугацаа дуусч элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн ашиглалтгүй болсон үндсэн хөрөнгө, бараа материалыг өмч хамгаалах байнгын зөвлөлөөр оруулж холбогдох арга хэмжээ авах, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т заасныг мөрдөх,

- Тус байгууллагын бүртгэлд нийт 20.3 сая төгрөгийн дансны үнэ бүхий 692 толгой мал бүртгэгдэж, малын тооллого, нас дэвшилтийг, зохих журмын дагуу хийгдэж байгаа ба зарим нэр төрлийн малын анхны өртөг өөр өөр байна.

**Шийдвэрлэсэн нь:** Малын анхны өртгийг бодитоор үнэлэх, ЦЕГ-ын Санхүү, ар талын газрын даргын 2010 оны 131 дугаар тушаалын 2-т “Зах зээлийн ханш, үнийн өөрчлөлттэй холбогдуулан жил бүр малын үнийг тогтоож батлуулах” гэж заасныг мөрдөж ажиллах.



## **Арван нэг. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар**

Аудитаар залруулагдаагүй алдаа байхгүй болно.

## **Арван хоёр. Анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

## **Арван гурав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд**

ЦЕГ-ын Санхүү хангамжийн газрын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

## **Арван дөрөв. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл**

ЦЕГ-ын Санхүү хангамжийн газрын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 49.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар удирдлагын анхааралд хандуулж 3 зөвлөмж өгсөн болно.

## **Арван тав. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

ЦЕГ-ын Санхүү хангамжийн газрын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна

### **Арван зургаа. Зөвлөмж**

2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3 зөвлөмж өгч байна.

/Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн -талаар/ Агуулга 10-т дэлгэрэнгүй байна.

## **Арван долоо. Зөрчилгүй санал дүгнэлт**

ЦЕГ-ын Санхүү хангамжийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан /. . . хуудас/-ыг хавсаргав.

### **АУДИТЫН ТАЙЛАНГ**

#### **ХЯНАСАН:**

**ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР**

**Ц.НАРАНЧИМЭГ**

**АУДИТЫН МЕНЕЖЕР**

**Г.ГҮНЖИДМАА**

#### **БЭЛТГЭСЭН:**

**АХЛАХ АУДИТОР**

**Ж.БАТСАЙХАН**

**АУДИТОР**

**Ш.ОТГОНБАЯР**

**ШИНЖЭЭЧ**

**Д.ЦЭГМИДДОРЖ**

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

2017 оны 2 дугаар сар



**YAG**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН САНХҮҮ ХАНГАМЖИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол № 3 зүйлс:

#### Асуудал 1

Мөнгөн хөрөнгийн талаар .....хуудас 3

#### Асуудал 2

Үндсэн хөрөнгийн талаар .....хуудас 4

#### Асуудал 3

Бараа материалын талаар .....хуудас 5

## Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг ЦЕГ-ын Санхүү хангамжийн газрын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулж болох зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга нь АОУС-ын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь ЦЕГ-ын Санхүү хангамжийн газрын хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын зөвлөмжүүд дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар эдгээрх зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин эдгээрх зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан ЦЕГ-ын Санхүү хангамжийн газрын санхүүгийн болон бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдагдсан зүйлсийг ач холбогдлынх нь дарааллаар дурдвал:

- Цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлууд;
- Удирдлагын анхаарах шаардлагатай асуудлууд;

## Асуудал 1 Мөнгөн хөрөнгийн талаар

## Тэргүүлэх ач холбогдол № 1

### ҮАГ-ын ажиглалт

- Жижиг мөнгөн сангийн нийт 87.6 сая төгрөгийн 126 ажил гүйлгээг түүвэрлэн шалгахад, ЦЕГ-ын харьяа бусад газруудтай холбоотой 2.3 сая төгрөгийн зардлыг тус байгууллагын баталсан төсвөөс санхүүжүүлсэн байна.
- Нэмэлт төсвийн данснаас санхүүжүүлсэн 11 томилолтын батлагдсан зардлын төсөв зөрүүтэй хийгдсэн, нийт явах километр, зарцуулах шатахууныг зөрүүтэй бодож тооцоолсон байна. Дотоод хяналтыг сайжруулж ажиллах,
- Улсын филармонтой байгуулсан ажил гүйцэтгэх 2 гэрээний нийт 8.8 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас санхүүжүүлээгүй ба дээрх зардлыг ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшууллын зардлаас санхүүжүүлсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 2-р хавсралтанд заасантай нийцэхгүй байна.

### Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх, хэрэглэгчдэд буруу ташаа мэдээлэл өгөх.

### ҮАГ-ын зөвлөмжүүд

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 2-р хавсралтанд заасан зардлын эдийн засгийн ангилалыг дагаж мөрдөх,

Цаашид ийм алдааг давтан гаргахгүй байх, дотоод хяналтыг сайжруулах,

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 8 дугаар сарын 5-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

### Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэн

**ҮАГ-ын ажиглалт**

- Тус байгууллагын үндсэн хөрөнгөд ашиглалтын хугацаа дуусч элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, ашиглалтгүй болсон цаашид ашиглах боломжгүй 15.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 2.7 сая төгрөгийн бараа материал бүртгэлтэй байна. Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр оруулж холбогдох арга хэмжээ авч ажиллах..

**ҮАГ-ын зөвлөмжүүд**

Ашиглалтын хугацаа дуусч элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн ашиглалтгүй болсон үндсэн хөрөнгө, бараа материалыг өмч хамгаалах байнгын зөвлөлөөр оруулж холбогдох арга хэмжээ авах,  
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах.

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 8 дугаар сарын 5-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, хэрэглэгчдэд буруу ташаа мэдээлэл өгөх,

**Үйлчлүүлэгчийн хариу**

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

**ҮАГ-ын ажиглалт**

Тус байгууллагын бүртгэлд нийт 20.3 сая төгрөгийн дансны үнэ бүхий 692 толгой мал бүртгэгдэж, малын тооллого, нас дэвшилтийг, зохих журмын дагуу хийгдэж байгаа ба зарим нэр төрлийн малын анхны өртөг өөр өөр байна. Мөн ЦЕГ-ын Санхүү, ар талын газрын даргын 2010 оны 131 дугаар тушаалын 2-т заасныг мөрдөж ажиллах.

**ҮАГ-ын зөвлөмжүүд**

Малын анхны өртгийг бодитоор үнэлэх, ЦЕГ-ын Санхүү, ар талын газрын даргын 2010 оны 131 дугаар тушаалын 2-т “Зах зээлийн ханш, үнийн өөрчлөлттэй холбогдуулан жил бүр малын үнийг тогтоож батлуулах” гэж заасныг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 8 дугаар сарын 5-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайланд материалын дүн буруу илэрхийлэгдэх, ашиглал шамшигдал үүсэх, бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах

**Үйлчлүүлэгчийн хариу**

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.





**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН, САНХҮҮ ХАНГАМЖИЙН ГАЗАР**  
**АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**  
 2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,706,222,416.91</b>	<b>3,517,421,299.18</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	350,000.00	350,000.00
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	350,000.00	350,000.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	67,932,041.75	53,951,450.75
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	67,932,041.75	53,951,450.75
3351	Байгууллагаас авах авлага	65,809,783.75	49,688,137.75
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,122,258.00	4,263,313.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	1,182,152,760.24	1,109,331,617.74
34600	Урьдчилж гарсан зардал	319,730,850.00	686,634,620.00
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	862,421,910.24	422,696,997.74
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	852,373,852.74	387,041,597.74
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа		35,655,400.00
34714	Томилолтын урьдчилгаа	10,048,057.50	
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	2,455,787,614.92	2,353,788,230.69
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,480,546,717.91	1,830,239,161.31
35110	Тусгай зориулалттай материал	1,478,949,437.91	1,828,641,881.31
35130	Эм боох материал	1,597,280.00	1,597,280.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	806,875,243.00	231,702,097.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	796,660.00	796,660.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	147,720,519.01	270,719,837.38
35410	Бичиг хэргийн материал	25,141,793.00	85,107,540.00
35420	Аж ахуйн материал	2,699,596.00	3,565,705.00
35440	Түлш, шатах тослох материал	7,016,000.00	5,625,000.00
35470	Бусад хангамжийн материал	112,863,130.01	176,421,592.38
35600	Мал амьтад	19,848,475.00	20,330,475.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>7,709,716,066.40</b>	<b>7,486,782,677.40</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	7,709,716,066.40	7,486,782,677.40
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	7,709,486,899.76	7,486,608,510.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,746,194,252.00	4,314,338,633.97
39202	Хуримтлагдсан элэгдэл	(353,799,691.49)	(505,549,820.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	95,042,053.84	70,533,203.84
39206	Хуримтлагдсан элэгдэл	(65,310,025.29)	(57,749,720.80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,094,630.13	3,396,879.39
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,472,920.02)	(1,929,928.67)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	2,411,838,111.88	2,414,355,249.88
39212	Хуримтлагдсан элэгдэл	(63,265,123.56)	(84,629,828.56)
39214	Бусад үндсэн хөрөнгө	118,747,502.56	116,531,109.56
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,759,464.29)	(4,866,586.77)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	1,821,177,574.00	1,222,179,319.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	229,166.64	174,166.68
39301	Програм хангамж	275,000.00	275,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(45,833.36)	(100,833.32)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>11,415,938,483.31</b>	<b>11,004,203,976.58</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>547,865,877.68</b>	<b>14,960,846.68</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	547,865,877.68	14,960,846.68
<b>413</b>	<b>Өглөг</b>	542,382,467.68	6,802,976.68
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	542,382,467.68	6,802,976.68
41361	Байгууллагад төлөх өглөг	542,023,757.68	6,802,976.68
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	358,710.00	
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	5,483,410.00	8,157,870.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	5,483,410.00	8,157,870.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>10,868,072,605.63</b>	<b>10,989,243,129.90</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	10,868,072,605.63	10,989,243,129.90
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	93,543,721.40	93,543,721.40
51101	Өмч: - төрийн	93,543,721.40	93,543,721.40

<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	10,774,320,729.51	10,895,491,253.78
51210	Өмнөх үеийн үр дүн	10,774,320,729.51	10,745,383,195.74
51220	Тайлант үеийн үр дүн		150,108,058.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	208,154.72	208,154.72
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>11,415,938,483.31</u></b>	<b><u>11,004,203,976.58</u></b>

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН, САНХҮҮ ХАНГАМЖИЙН ГАЗАР**  
**АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**  
 2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>24,781,443,756.06</b>	<b>30,083,348,685.23</b>
12	<b>ТАТВАРЫН БҮС ОРЛОГО</b>	<b>3,781,845,507.86</b>	<b>4,523,579,099.23</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,781,845,507.86</b>	<b>4,523,579,099.23</b>
120003	Торгуулийн орлого	64,223,800.00	78,046,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,918,253,885.81	4,178,336,163.26
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,680,555,088.00	2,537,064,067.82
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	215,503,209.11	83,532,049.95
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	22,195,588.70	1,557,740,045.49
120009	Бусад орлого	1,799,367,822.05	267,196,035.97
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>20,999,598,248.20</b>	<b>25,559,769,586.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>20,614,482,144.00</b>	<b>24,063,394,968.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	17,039,212,387.00	21,021,765,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	3,575,269,757.00	3,041,629,968.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>385,116,104.20</b>	<b>1,496,374,618.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	41,130,000.00	113,909,850.00
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	313,486,104.20	728,612,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,500,000.00	653,802,768.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		50,000.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>22,206,760,602.71</b>	<b>29,915,708,729.52</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>22,206,755,782.54</b>	<b>29,915,708,729.52</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>16,587,365,167.68</b>	<b>19,875,885,751.44</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>3,517,040,430.00</b>	<b>3,930,558,414.00</b>
210101	Үндсэн цалин	2,070,901,047.00	2,058,802,649.00
210102	Нэмэгдэл	1,406,165,067.00	1,863,976,165.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,702,800.00	7,779,600.00
210104	Урамшуулал	31,271,516.00	
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>91,423,287.00</b>	<b>97,696,200.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	19,530,382.00	16,910,303.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,232,043.00	1,912,363.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,790,052.00	2,390,454.00
210204	Ажилгүйдлийн даатгал	378,022.00	373,834.00
210205	Эрүүл мэндийн даатгал	66,492,788.00	76,109,246.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>11,191,602.98</b>	<b>7,693,597.58</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,257,137.00	1,990,119.00
210302	Түлш, халаалт		4,177,935.58
210303	Цэвэр, бохир ус	934,465.98	1,525,543.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>225,124,940.17</b>	<b>160,947,366.44</b>
210401	Бичиг хэрэг	128,301,117.70	56,631,570.50
210402	Тээвэр, шатахуун	5,756,000.00	21,169,690.00
210403	Шүүдан, холбоо, интернэтийн төлбөр	30,786,874.40	50,046,234.59
210404	Ном хэвлэл	12,707,200.00	24,205,140.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		353,298.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	9,966,282.20	8,541,433.35
210408	Бараа материал актальсны зардал	37,607,465.87	
2105	<b>Нормативт зардал</b>	<b>145,057,832.20</b>	<b>402,666,034.57</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,377,625.00	1,523,643.00
210502	Хоол, хүнс	122,532,153.00	397,486,070.39
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	21,148,054.20	3,656,321.18
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>60,312,007.00</b>	<b>220,627,181.00</b>
210601	Багаж, техник хэрэгсэл		172,970,608.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	232,500.00	643,650.00
210604	Урсгал засвар	60,079,507.00	47,012,923.00
2107	<b>Томилolt, зочны зардал</b>	<b>95,500,064.12</b>	<b>130,248,341.61</b>
210701	Гадаад албан томилolt	56,795,691.00	1,763,510.00
210702	Дотоод албан томилolt	31,647,308.00	109,226,869.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	7,057,065.12	19,257,962.61
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,234,219,823.20</b>	<b>1,626,014,062.61</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	136,563,290.00	159,421,590.00
210803	Даатгалын үйлчилгээ	214,321,285.20	224,589,024.61
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	28,608,120.00	17,747,520.00
210807	Газрын төлбөр	5,115,504.00	1,156,196.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	849,611,624.00	1,223,099,732.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,207,495,181.01</b>	<b>13,299,434,553.63</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,958,206,954.61	12,970,182,021.03
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	81,435,816.96	139,253,431.30
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	167,852,409.44	189,999,101.30
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,619,390,614.86</b>	<b>10,039,822,978.08</b>
2131	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>34,086,360.00</b>	<b>37,208,910.00</b>
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	34,086,360.00	37,208,910.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,573,602,278.90</b>	<b>7,276,874,728.13</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		111,151,898.13

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,306,346,614.00	5,968,631,130.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,155,282,553.00	1,197,091,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	111,973,111.90	
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	2,011,701,975.96	2,725,739,339.95
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	265,785,133.76	102,247,647.13
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,745,916,842.20	2,623,491,692.82
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,820.17</b>	-
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>4,820.17</b>	-
222001	Тоног төхөөрөмж	4,820.17	
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>2,574,683,153.35</b>	<b>167,639,955.71</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	274,166.49	17,531,897.67
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	274,166.49	17,531,897.67
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(274,166.49)	(17,531,897.67)
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>2,574,408,986.86</b>	<b>150,108,058.04</b>

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН, САНХҮҮ ХАНГАМЖИЙН ГАЗАР**  
**АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/Төрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>23,057,910,510.44</b>	<b>28,482,367,083.44</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,045,876,964.49</b>	<b>2,839,163,630.69</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,045,876,964.49	2,839,163,630.69
120003	Торгуулийн орлого	64,223,800.00	78,046,900.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	1,981,653,164.49	2,761,116,730.69
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,680,689,688.00	2,537,974,067.82
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,963,476.49	223,142,662.87
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>21,012,033,545.95</b>	<b>25,643,203,452.75</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	20,614,482,144.00	24,063,394,968.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	17,039,212,387.00	21,021,765,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	3,575,269,757.00	3,041,629,968.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	397,551,401.95	1,579,808,484.75
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	41,130,000.00	113,909,850.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	313,486,104.20	728,612,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,500,000.00	653,802,768.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		57,259,689.00
131106	Төсвийн урамшуулал	12,435,297.75	26,224,177.75
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>19,478,865,753.44</b>	<b>25,437,965,314.84</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>19,478,865,753.44</b>	<b>25,437,965,314.84</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>13,770,395,001.73</b>	<b>15,402,387,402.14</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	6,686,169,472.00	5,058,700,768.26
210101	Үндсэн цалин	4,690,804,924.00	4,013,128,404.26
210102	Нэмэгдэл	1,995,364,548.00	1,045,572,364.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	153,942,155.00	124,293,177.55
210201	Тэтгэврийн даатгал	153,942,155.00	19,669,558.55
210202	Тэтгэмжийн даатгал		1,912,363.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		2,390,454.00
210204	Ажилгүйдлийн даатгал		373,834.00
210205	Эрүүл мэндийн даатгал		99,946,968.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	377,559,104.13	422,957,684.81
210301	Гэрэл, цахилгаан	41,702,359.00	52,400,859.49
210302	Түлш, халаалт	330,425,219.37	363,265,062.16
210303	Цэвэр, бохир ус	5,431,525.76	4,856,383.16
210304	Байрны түрээс		2,435,380.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	370,713,381.03	823,170,038.88
210401	Бичиг хэрэг	148,657,524.00	219,748,598.00
210402	Тээвэр, шатахуун	124,999,900.00	419,191,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	53,654,161.03	107,378,628.88
210404	Ном, хэвлэл	26,693,680.00	62,613,640.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,592,298.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,708,116.00	12,645,124.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	3,608,036,827.37	4,982,775,553.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,921,245.00	3,833,483.00
210502	Хоол, хүнс	124,933,255.00	751,206,295.26
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,481,182,327.37	4,227,735,775.54
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	415,180,780.00	1,328,082,422.60
210601	Багаж, техник, хэрэгсэл	150,241,203.00	612,496,959.60
210602	Тавилга	35,137,505.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	29,151,572.00	24,715,650.00
210604	Урсгал засвар	200,650,500.00	690,869,813.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	96,989,565.00	332,963,744.17
210701	Гадаад албан томилолт	51,193,151.00	4,782,410.00

210702	Дотоод албан томилолт	38,143,110.00	195,791,724.50
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	7,653,304.00	132,389,609.67
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,723,100,324.20</b>	<b>2,190,847,435.97</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	304,688,895.00	253,967,144.00
210803	Даатгалын үйлчилгээ	214,321,285.20	225,933,944.97
210804	Тээврийн хэрэгслийн татвар	8,671,707.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	40,107,240.00	82,584,320.00
210807	Газрын төлбөр	20,311,197.00	11,651,938.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,135,000,000.00	1,616,710,089.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>338,703,393.00</b>	<b>138,596,576.10</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	261,970,078.00	15,132,446.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	76,733,315.00	123,464,129.70
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,708,470,751.71</b>	<b>10,035,577,912.70</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>34,086,360.00</b>	<b>37,208,910.00</b>
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	34,086,360.00	37,208,910.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,636,458,238.00</b>	<b>7,225,549,025.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		96,672,125.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,419,686,300.00	5,931,785,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,155,279,053.00	1,197,091,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	61,492,885.00	
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,037,926,153.71</b>	<b>2,772,819,977.70</b>
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	265,785,133.76	102,247,647.13
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,772,141,019.95	2,670,572,330.57
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>3,579,044,757.00</u></b>	<b><u>3,044,401,768.60</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b><u>3,579,044,757.00</u></b>	<b><u>3,044,401,768.00</u></b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b><u>3,579,044,757.00</u></b>	<b><u>3,044,401,768.00</u></b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>3,579,044,757.00</b>	<b>3,044,401,768.00</b>
220001	Барилга байгууламж	1,958,631,021.00	1,987,317,331.00
221001	Их засвар		264,400,394.00
222001	Тоног төхөөрөмж	1,215,836,930.75	789,912,243.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	404,576,805.25	2,771,800.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>3,579,044,757.00</u></b>	<b><u>3,044,401,768.00</u></b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>350,000.00</b>	<b>350,000.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>350,000.00</b>	<b>350,000.00</b>

## ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН, САНХҮҮ ХАНГАМЖИЙН ГАЗАР

ТГ

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,964,183,400.00	17,054,744,588.73	21,396,838,900.00	21,142,660,015.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,964,183,400.00	17,054,744,588.73	21,396,838,900.00	21,142,660,015.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,225,392,600.00	13,393,199,990.73	14,115,338,200.00	13,879,902,080.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,686,229,800.00	6,686,169,472.00	5,082,154,600.00	5,058,700,768.26
210101	Үндсэн цалин	3,970,155,500.00	4,690,804,924.00	4,128,910,600.00	4,013,128,404.26
210102	Нэмэгдэл	2,712,984,700.00	1,995,364,548.00	932,077,400.00	1,045,572,364.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт			21,166,600.00	
210105	Гэрээт ажлын хөлс	3,089,600.00			
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	164,224,400.00	153,942,155.00	180,330,900.00	124,293,177.55
210201	Тэтгэврийн даатгал	164,224,400.00	153,942,155.00	21,571,500.00	19,669,558.55
210202	Тэтгэмжийн даатгал			2,309,600.00	1,912,363.00
210203	ҮОМШӨ-ний даатгал			3,040,200.00	2,390,454.00
210204	Ажилгүйдлийн даатгал			350,300.00	373,834.00
210205	Эрүүл мэндийн даатгал			153,059,300.00	99,946,968.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	515,706,500.00	377,559,104.13	462,577,300.00	422,957,685.41
210301	Гэрэл, цахилгаан	203,603,200.00	41,702,359.00	66,303,600.00	52,400,859.49
210302	Түлш, халаалт	297,823,100.00	330,425,219.37	378,735,000.00	363,265,062.16
210303	Цэвэр, бохир ус	14,280,200.00	5,431,525.76	15,099,400.00	4,856,383.76
210304	Байрны түрээс			2,439,300.00	2,435,380.00
2104	Хангамж, бараа материалын зардал	380,827,900.00	370,713,381.03	729,906,600.00	668,522,188.88
210401	Бичиг хэрэг	148,424,400.00	148,657,524.00	237,914,400.00	218,748,598.00
210402	Тээвэр, шатахуун	125,000,000.00	124,999,900.00	306,937,200.00	296,242,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	54,172,600.00	53,654,161.03	93,305,500.00	81,669,628.88
210404	Ном, хэвлэл	33,130,900.00	26,693,680.00	58,000,000.00	57,623,640.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал			1,592,300.00	1,592,298.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,100,000.00	16,708,116.00	32,157,200.00	12,645,124.00
2105	Норматив зардал	3,980,329,600.00	3,608,036,827.37	4,486,065,200.00	4,530,440,653.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,979,700.00	1,921,245.00	4,066,000.00	3,833,483.00
210502	Хоол, хүнс	506,975,200.00	124,933,255.00	282,847,700.00	358,871,395.26
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,471,374,700.00	3,481,182,327.37	4,199,151,500.00	4,167,735,775.54
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	490,122,100.00	418,680,780.00	669,339,500.00	617,818,624.60
210601	Багаж, техник, хэрэгсэл	142,303,800.00	153,741,203.00	407,922,700.00	356,555,161.60
210602	Тавилга	45,320,000.00	35,137,505.00		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	101,812,400.00	29,151,572.00	18,498,600.00	24,715,650.00
210604	Урсгал засвар	200,685,900.00	200,650,500.00	242,918,200.00	236,547,813.00
2107	Томиллолт, зочны зардал	118,349,800.00	95,828,565.00	270,719,000.00	266,154,414.17
210701	Гадаад албан томиллолт	32,218,800.00	51,193,151.00	497,000.00	
210702	Дотоод албан томиллолт	60,897,300.00	36,982,110.00	135,222,000.00	133,764,804.50
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	25,233,700.00	7,653,304.00	135,000,000.00	132,389,609.67
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,781,320,500.00	1,598,933,499.20	2,088,701,500.00	2,058,219,691.97
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	215,268,400.00	180,247,070.00	169,417,600.00	159,343,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00			
210803	Даатгалын үйлчилгээ	214,341,800.00	214,321,285.20	229,515,100.00	225,933,944.97
210804	Тээврийн хэрэгслийн татвар	13,109,300.00	8,671,707.00	3,500,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	51,541,900.00	40,382,240.00	56,522,200.00	44,579,920.00
210807	Газрын төлбөр	21,059,100.00	20,311,197.00	12,446,600.00	11,651,938.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэл, бэлтгэх	1,265,000,000.00	1,135,000,000.00	1,617,300,000.00	1,616,710,089.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,282,000.00	83,336,207.00	145,543,600.00	132,794,876.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,442,200.00	6,602,892.00	22,039,500.00	15,132,446.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	95,839,800.00	76,733,315.00	123,504,100.00	117,662,429.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,738,790,800.00	3,661,544,598.00	7,281,500,700.00	7,262,757,935.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	39,325,000.00	34,086,360.00	39,325,000.00	37,208,910.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	39,325,000.00	34,086,360.00	39,325,000.00	37,208,910.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,699,465,800.00	3,627,458,238.00	7,242,175,700.00	7,225,549,025.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал			113,298,800.00	96,672,125.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,419,686,300.00	2,419,686,300.00	5,931,785,200.00	5,931,785,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,197,091,700.00	1,155,279,053.00	1,197,091,700.00	1,197,091,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	82,687,800.00	52,492,885.00		
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	17,964,183,400.00	17,054,744,588.73	21,396,838,900.00	21,142,660,015.74
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	17,277,569,100.00	16,773,427,253.24	21,096,838,900.00	20,919,517,352.87
131001	Улсын төсвөөс санхүүжих	17,277,569,100.00	16,773,427,253.24	21,096,838,900.00	20,919,517,352.87
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	686,614,300.00	281,317,335.49	300,000,000.00	223,142,662.87
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	232,185,000.00		264,227,600.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	454,429,300.00	281,317,335.49	35,772,400.00	223,142,662.87
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		350,000.00		350,000.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		350,000.00		350,000.00